# САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ГАЗАР, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Э.ЮМЖИРМААГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Нэгжийн нэр: Салбарын хяналт шалгалтын хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаа жуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Улсын хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх** | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1** Нийслэлийн хэмжээнд их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 12 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | 50 | 5 | 55 | |
| 2. | **Арга хэмжээ 1.2** Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Нийслэл дүүргийн Газар зохион байгуулалтын алба (2)-нд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | 60 | 10 | 70 | |
| 3. | **Арга хэмжээ 1.3** Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн "Газрын кадастрын цахим систем"-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | 50 | 10 | 60 | |
| 4. | **Арга хэмжээ 1.4** Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын газар олголт, иргэн, хуулийн этгээдийн газар ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | 60 | 10 | 70 | |
| 5. | **Арга хэмжээ 1.5** Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | 50 | 10 | 60 | |
| 6. | **Арга хэмжээ 1.6** Соёл, урлагийн байгууллагын газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | 50 | 10 | 60 | |
| 7. | **Арга хэмжээ 1.7** Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах | 50 | 10 | 60 | |
| 8. | **Арга хэмжээ 1.8** Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн нэгж талбарын цахим системд үүсгэсэн хувийн хэргийн (1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын) бүрдүүлэлтэд гүйцэтгэлийн хяналт хийх | 50 | 10 | 60 | |
| 9. | **Арга хэмжээ 1.9** Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төлөвлөх ажлын хүрээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | үзүүлэлтээр объектын эрсдэлийн үнэлгээ хийх | | | | |
| **Зорилт 2. Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барих** | | | | | |
| 10. | **Арга хэмжээ 2.1** Холбогдох эрх зүйн баримт, бичигт санал өгөх | 50 | 10 | 60 | |
| 11. | **Арга хэмжээ 2.2** Салбарын хяналт, шалгалтын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох | 50 | 10 | 60 | |
| 12. | **Арга хэмжээ 2.3** Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх хяналтын хуудсыг боловсруулж, батлуулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 3. Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох** | | | | | |
| 13. | **Арга хэмжээ 3.1** Салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, батлуулах | 60 | 10 | 70 | |
| 14. | **Арга хэмжээ 3.2** 2024 онд газар, геодези, зураг зүйн чиглэлээр хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулах | 60 | 10 | 70 | |
| 15. | **Арга хэмжээ 3.3** Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулах | 60 | 10 | 70 | |
| 16. | **Арга хэмжээ 3.4** Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээлэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 4. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | |
| 17. | **Арга хэмжээ 4.1** Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | 60 | 10 | 70 | |
| 18. | **Арга хэмжээ 4.2** Эрх бүхий байгууллага, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | 60 | 10 | 70 | |
| 19. | **Арга хэмжээ 4.3** Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 5. Хурал, зөвлөгөөн зохион байгуулах** | | | | | |
| 20. | **Арга хэмжээ 5.1** Хариуцлагатай газрын харилцаа аян зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 6. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | | | | | |
| 21. | **Арга хэмжээ 6.1** Аймгуудын газрын харилцаа, хот байгуулалтын газрын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах | 50 | 10 | 60 | |
| 22. | **Арга хэмжээ 6.2** Нийслэл, дүүргүүдийн газар зохион байгуулагч, бүртгэлийн мэргэжилтнүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулах | 50 | 10 | 60 | |
| **Зорилт 7. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 23. | **Арга хэмжээ 7.1** Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | 60 | 10 | 20 | |
| 24. | **Арга хэмжээ 7.2** Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | 60 | 10 | 20 | |
| 25. | **Арга хэмжээ 7.3** Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | 60 | 10 | 20 | |
| 26. | **Арга хэмжээ 7.4** Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивд баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивд хүлээлгэн өгөх | 60 | 10 | 20 | |
| **Дундаж оноо:** | | | | 65.9 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Төрийн албанд томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдах; | 80 | 12 | |
| 2. | **Арга хэмжээ 2** Зохион байгуулж буй сургалт, семинарт хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлэх | 80 | 12 | |
| 3. | **Арга хэмжээ 2** Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн сургалтад хамрагдах | 80 | 12 | |
| **Дундаж оноо** | | | 12 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 4 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 5 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | 6 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7.9 |
| 2. | Багаар ажиллах | 7.9 |
| 3. | Харилцаа | 7.9 |
| **Дундаж оноо** | | 7.9 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 65.9 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 12 |

| | | |
|---|---|---|
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*( Нэгжийн даргын үнэлгээ )* | 6 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | 7.9 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 91.8 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Салбарын хяналт, шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............ (Д.Тувшинбат)
2024.12.05

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч ............ (Э.Юмжирмаа)
2024.12.05

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Төрийн захиргаа, удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............ (Б.Энхболд)
2024.12.05

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн ............ (С.Ганцэцэг)
2024.12.05

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга ............ (А.Энхманлай)
2024.12.19

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт*

## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Албан хаагчийн овог, нэр: Энхчуягийн Юмжирмаа

Ярилцлага хийсэн огноо: 2024 оны 10 сарын 01 өдөр

Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай | Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар |
|---|---|---|---|
| | **Зорилт 3. Хурал, зөвлөгөөн зохион байгуулах** | | |
| 1. | Улсын хэмжээнд газар, геодези, зураг зүйн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 299 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | Төрийн хяналт шалгалтын нэгдсэн Шилэн хяналтын системийг хяналт шалгалтын байгууллагууд ашиглах. | Төрийн хяналт шалгалтын нэгдсэн Шилэн хяналтын системийг хяналт шалгалтын байгууллагууд ашиглах болсонтой холбогдуулан 2024 оны салбарын хэмжээнд хийгдсэн төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлээр хийгдсэн бүх хяналт шалгалттай холбоотой мэдээллийг улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж хөтлөх ажлыг зохион байгуулах. |
| 2. | Нийслэлийн хэмжээнд их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 12 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | | |

**ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:**

САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ........................ (Д.ТҮВШИНБАТ)

179

# САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ГАЗАР, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Э.ЮМЖИРМААГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Улсын хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1** Нийслэлийн хэмжээнд их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 12 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулсан хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | Шалгалтаар эрсдэл үүсгэх магадлалын хувь 13% хууль сахин мөрдөлтийн хувь 86.9% байсан бол гүйцэтгэлийн шалгалтаар эрсдэл үүсгэх магадлалын хувь 8.9% хууль сахин мөрдөлтийн хувь 92.9% болж, нийт эрсдэлийн хувь 4.1%-аар буурсан, хууль сахин мөрдөлтийн хувь 6%-аар өссөн. | Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулна.<br>Хяналт шалгалтыг эхлүүлсэн байна.<br>Шалгалтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт объектын эрсдэлийн түвшнийг бууруулсан байна.<br>Хяналтын хуудсаар илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | Газрын даргын 2024 оны А/53 дугаар тушаалаар газар, геодези, зураг зүйн салбарын 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 60 обьект /нийслэлийн хэмжээнд/-ын жагсаалт батлагдсан.<br>Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай 35-00/03 дугаартай удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалт хийж жилийн эцсийн байдлаар 10 объектод хяналт шалгалт хийхээс 8 обьектыг хяналтын хуудсаар үнэлэхэд бага эрсдэлтэй үнэлэгдэж, эрслийн дундаж хувь 12,3, хууль сахин мөрдөлтийн дундаж хувь 86,2 байна. Бусад 4 объектийн үйл ажиллагаа зогссон тул үнэлэх боломжгүй учир албан бичгээр тайлбар авч хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн 10 обкъектийг “Шилэн хяналт” системд бүрэн оруулсан. Хяналт шалгалт хийгдсэн обьектуудад илэрсэн нийтлэг алдаа | 10-11 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. | | |
| 2. | **Арга хэмжээ 1.2**<br>Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Нийслэл дүүргийн Газар зохион байгуулалтын алба (2)-нд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | - | Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулна.<br>Хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлсэн байна.<br>Илэрсэн зөрчилд холбогдох арга хэмжээг авна. | Тус ажлын хүрээнд Салбарын улсын ерөнхий байцаагчийн 35-00/04 дугаартай удирдамж батлуулж Баянгол дүүргийн Газар зохион байгуулалтын алба болон Сүхбаатар дүүргийн Газар зохион байгуулалтын албанд төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн. Баянгол дүүргийн Газар зохион байгуулалтын алба болон Сүхбаатар дүүргийн Газар зохион байгуулалтын албаны хэмжээнд эрх бүхий этгээдийн шийдвэр гарч иргэн, хуулийн этгээдэд олгосон 48530 нэгж талбарын мэдээллийг нарийвчлан шалгаж газар олголтын байдал, дуудлага худалдаа, төлбөрийн мэдээлэл, талбайн хэмжээ болон зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэх хяналтын ажлыг гүйцэтгэж ажлын үр дүнг 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр газрын даргад танилцуулсан бөгөөд Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу холбогдох дүүргүүдэд ажил сайжруулах чиглэл хүргүүлсэн. | 1-6 | |
| 3. | **Арга хэмжээ 1.3**<br>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн "Газрын кадастрын цахим систем"-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн "Газрын кадастрын цахим систем"-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулна.<br>Хяналт шалгалтыг эхлүүлсэн байна. | Тус ажлын хүрээнд Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн "Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай" 35-00/08 дугаартай удирдамжийг боловсруулан батлуулсан бөгөөд тус удирдамжийг үндэслэн газрын даргын 2024 оны 09 | 1-9 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | хяналт хийх, дүгнэлт гаргах, авах арга хэмжээний саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийн дагуу цахим системд үүсгэсэн хувийн хэргийн 1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын бүрдүүлэлтэд хяналт хийсэн. | | дүгээр сарын 23-ны өдрийн А/272 тоот ажлын хэсгийг 21 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж авч хэрэгжүүлэх арга хэмжээ, календарчилсан төлөвлөгөөг баталсан. Нийслэлийн хэмжээнд цахим хувийн хэргүүдэд тус тус урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт хийж үзэхэд Хяналт шалгалт хийгдсэн нийт материалаас зөв материал оруулсан, дутуу материал оруулсан, бөөнд нь сканердаж оруулсан, буруу материал оруулсан, хоосон цаас оруулсан бүрдүүлэтийг шалгасан Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид анхаарч ажиллах улсын байцаагчийн зөвлөмжийг 21 аймгийн ГХБХБГ болон Нийслэлийн ГЗБА-нд хүргүүлсэн. | | |
| 4. | **Арга хэмжээ 1.4**<br>Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын газар олголт, иргэн, хуулийн этгээдийн газар ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо, гүйцэтгэлийн хувь, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | - | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулна.<br>Хяналт шалгалтыг эхлүүлсэн байна. | Тус арга хэмжээг гүйцэтгэхээр Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай 35-00/07 дугаартай удирдамжийг батлуулсан. Тус удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумдад ажиллах бүрэлдэхүүн, албан томилолтын зардлыг газрын даргын 2024 оны 06 дугаар сарын А/204 дүгээр тушаалаар батлуулсан.<br>Батлагдсан удирдамжийн дагуу Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд 2024 оны 10 дугаар сарын 01-ээс 06-ны өдрүүдэд ажиллаж урьдчилсан сэргийлэх хяналт | 1-12 | |

198

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгалт хийсэн. Шалгалтаар Эрдэнэцагаан сумын нийт газар олголт болон Бичигт боомтын газар ашиглалтын нөхцөл байдалд нарийвчилсан хяналт хийж танилцуулга бэлтгэн байгууллагын удирдлагуудад танилцуулсан.<br>Өмнөговь аймгийн Цогтцэций сумын хэмжээнд хийгдсэн газар олголтын байдалд 41 сумдын хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын ажлын үеэр хийгдсэн судалгааны материалд үндэслэн холбогдох танилцуулгыг боловсруулсан. Нийт ажлын үр дүнг Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсэгт танилцуулсан. | | |
| 5. | **Арга хэмжээ 1.5**<br>Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | - | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулна.<br>Илэрсэн зөрчилд холбогдох арга хэмжээг авна. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай 35-00/12 дугаартай удирдамжийг батлуулсан бөгөөд тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн судалгааг гаргаж үзэхэд Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 225, Газар зохион байгуулалт, газрын мониторингийн тусгай зөвшөөрөлтэй 152 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс Газрын мониторинг, хянан баталгааны тайлан боловсруулж буй тусгай зөвшөөрөлтэй 8 байгууллагыг сонгон авч урьдчилсан сэргийлэх хяналт шалгалтыг гүйцэтгэж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай нийт 32 заалт бүхий хугацаатай албан | 1-9 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлага хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг хангуулсан. | | |
| 6. | **Арга хэмжээ 1.6** Соёл, урлагийн байгууллагын газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | - | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулна. Хяналт шалгалтыг эхлүүлсэн байна. | Соёл, урлагийн байгууллагын газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх зорилгоор Соёлын салбарын ерөнхий байцаагч, газрын салбарын ерөнхий байцаагчдын хамтарсан 35/00/06, 05-00-00-001/07 дугаартай удирдамжийг батлуулж нийслэл, дүүрэгт газар эзэмшиж байгаа соёл, урлаг, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын зориулалтаар газар эзэмшиж байгаа 30 байгууллагын газрын захирамжлалын түүхчилсэн мэдээлэлд урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт хийгдсэн. | 4-11 | |
| 7. | **Арга хэмжээ 1.7** Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | - | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулна. Хяналт шалгалтыг эхлүүлсэн байна. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 35-00/05 дугаартай удирдамжийг боловсруулан газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж Нийслэлийн хэмжээнд газар эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээд, байгууллагын судалгааг гарган Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран зөчлийг арилгуулах арга хэмжээг авч ажилласан.<br>Улсын хэмжээнд 1220 зөрчлийг арилгуулан нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлүүлсэн. | 1-12 | |

182

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | **Арга хэмжээ 1.8**<br>Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн нэгж талбарын цахим системд үүсгэсэн хувийн хэргийн (1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын) бүрдүүлэлтэд гүйцэтгэлийн хяналт хийх | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | "Газрын кадастрын цахим систем"-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд удирдамжийн дагуу цахим системд үүсгэсэн хувийн хэргийн 1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын хувийн бүрдүүлэлтэд хяналт хийсэн. | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулна.<br>Илэрсэн зөрчилд холбогдох арга хэмжээг авна. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай 35-00/11 дугаартай удирдамжийн дагуу Нийслэл, дүүрэг, аймаг, сумын хэмжээнд "Газрын кадастрын цахим систем"-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд гүйцэтгэлийн хяналт хийгдэж өмнөх онд гүйцэтгэсэн цахим хувийн хэргийн 195 цахим хувийн хэрэгт гүйцэтгэлийн хяналт шалгалтын ажлийг гүйцэтгэсэн.<br>Хяналт шалгалт хийгдсэн материалаас зөв материал оруулсан 11.1 хувь, дутуу материал оруулсан 7,6 хувь, бөөнд нь сканердаж оруулсан 6,8 хувь, буруу материал оруулсан 8,6 хувь, хоосон цаас оруулсан 1.6 хувьтай тус тус бүрдүүлсэн байна. Цаашид зөрчил гаргахгүй байх, цахим архивын хөтлөлтийн талаар анхаарч ажиллах, илэрсэн зөрчлүүдийг арилгаагүй, давтан үйлдсэн тохиолдолд холбогдох албан хаагчдад арга хэмжээ авах талаар чиглэл хүргүүлсэн. | 3-12 | |
| 9. | **Арга хэмжээ 1.9**<br>Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төлөвлөх ажлын хүрээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийн үнэлгээ хийх | Эрсдэлийг үнэлсэн байдал | Шилэн хяналтын цахим системд 2023 онд 2185 объектын эрсдэлийн үнэлгээг хийн бүртгэж, нэгдсэн цахим санг бүрдүүлсэн. | - | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төлөвлөх ажлын хүрээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр 2024 онд нийт 51 обьектод эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлгээг хийж төрийн хяналт шалгалтын "Шилэн хяналт"-ын системд 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр оруулж эцэслэсэн. | 10-11 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2. Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барих** | | | | | | | |
| 10. | **Арга хэмжээ 2.1**<br>Холбогдох эрх зүйн баримт, бичигт санал өгөх | Санал өгсөн төслийн тоо | Газрын даргын 2023 оны А/159 дүгээр тушаалаар Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлал, танилцуулга бэлтгэн хүргүүлсэн болно. | Холбогдох эрх зүйн баримт, бичигт санал өгч холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байна. | Нийслэлийн газрын эрхийн маргаан таслах зөвлөлийн ажиллах журмын төсөлд 18 санал, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журмын төсөлд 3 санал боловсруулан хуулийн хэлтэст хүргүүлсэн.<br>Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага, стандартад 3 санал боловсруулан хуулийн хэлтэст өгсөн.<br>Эхэлсэн, дууссан огноо: | 1-8 | |
| 11. | **Арга хэмжээ 2.2**<br>Салбарын хяналт, шалгалтын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Боловсруулсан журмын төслийн тоо | Шинэчлэн найруулсан Газрын ерөнхий хуулийн төсөлд 2, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн төсөлд 1 санал, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгад 1 саналыг хүргүүлсэн. | Журмын төслийг боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байна. | Салбарын хяналт, шалгалтын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор дараах журмуудад санал өгч батлуулсан.<br>1. Хяналт шалгалтын баримт бичигт дугаар олгох, хадгалах журам төсөл боловсруулсан. Газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/51 дугаар тушаалаар баталсан.<br>2. Геодези, зураг зүйн хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх 2 хяналтын хуудас боловсруулсан. Газрын даргын 2024 оны А/85 тушаалаар баталсан<br>3. Хот байгуулалт, уул уурхайн ашиглалт, ашигт малтмалын нөөц тооцоолол, барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, инженерийн дэд бүтцийн геодезийн хэмжилтийн үйл ажиллагааг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт; Геодези, зураг зүйн тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийн эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтүүдийг шинээр боловсруулан холбогдох хэлтэст хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн | 1-8 | |

18

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Газрын 2024 оны 24 дугаар тогтоолоор баталсан. | | |
| 12. | **Арга хэмжээ 2.3**<br>Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх хяналтын хуудсыг боловсруулж, батлуулах | Шинээр болон шинэчлэн боловсруулсан хяналтын хуудасны тоо | Хяналтын хуудсанд нэмэлт өөрчлөлт оруулах 3 саналыг хүргүүлэн Барилга, хот, байгуулалтын сайдын 2023.02.10-ны өдрийн 25 дугаар тушаалаар батлуулав. | - | Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэх 5 хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулахад санал өгч, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2024 оны А/85 дугаар тушаалаар хяналтын хуудасны нэр, хяналтын хуудсыг батлуулсан болно. | 1-8 | |
| **Зорилт 3. Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох** | | | | | | | |
| 13. | **Арга хэмжээ 3.1**<br>Салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, батлуулах | Боловсруулсан шалгуур, үзүүлэлтийн тоо | газар эзэмшигч, ашиглагч этгээдийн шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах төсөлд 2 саналыг хүргүүлэн Засгийн газрын 2023.05.24-.ний өдрийн 195 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлуулсан. | - | Салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтэл санал өгч, шинэчлэн боловсруулж, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор хавсралтад өөрчлөлт оруулсан. | 1-6 | |
| 14. | **Арга хэмжээ 3.2**<br>2024 онд газар, геодези, зураг зүйн чиглэлээр хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулах | Хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулсан байдал | Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 12 объектод төлөвлөгөөт шалгалт хийхээр “Хяналт шалгалтын төлөвлөгөөг” Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>- Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 74 дүгээр тушаалаар батлуулсан. | - | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2024 оны А/53 дугаар тушаалаар газар, геодези, зураг зүйн салбарын 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 12 обьектын жагсаалтыг батлуулсан. | 1-6 | |

18

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15. | **Арга хэмжээ 3.3**<br>Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулах | Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулсан байдал | Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 74 дүгээр тушаалаар 2023 онд 251 объектод хяналт шалгалт хийсэн. | - | Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 330 объектын жагсаалтыг боловсруулан Засгийн газрын Хяналт үнэлгээний үндэсний хороонд 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр хүргүүлж батлагдсан. Одоогор батлагдсан төлөвлөгөө ЗГХҮҮХ-оос ирээгүй байна. | 10-11 | |
| 16. | **Арга хэмжээ 3.4**<br>Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээлэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | Сургалтын тоо<br>Хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн тоо | - | - | Байгууллагын цахим сайтад Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааны чиглэл, хяналт шалгалтын эрх зүйн орчин, эрсдэлийн шалгуур үзүүлэлт, хяналтын хуудас, хяналт шалгалтын төлөвлөгөөг байршуулсан.<br>Увс, Дорноговь аймагт зохион байгуулагдсан баруун болон говийн бүсийн аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагч, сумдын даамлуудыг чадавхжуулах сургалтад оролцон мэдээлэл хийсэн.<br>Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, сууц өмчлөгчдийн дээд зөвлөлтэй хамтран сууц өмчлөгчдийн холбооны дарга нарт салбарын хууль тогтоомжийг сурталчлах, газар ашиглалтын байдал, газрын харилцааны цахим шилжилт, газрын хуулийн өөрчлөлт, сууц өмчлөгчдийн холбооны газар ашиглалтын эрх, үүрэг, нийтлэг зөрчил, газрын зөрчил, маргаан, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгч, сургалт зохион байгуулсан байна. Мөн 9 дүүрэгт баг, хорооны Засаг дарга, дүүргүүдийн | 1-9 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Газрын албатай хамтран 769 иргэн, хуулийн этгээдийг хамруулан сургалт зохион байгуулсан. Сургалтаар хийгдэж буй ажил, хуулинд орсон өөрчлөлт, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн ач холбогдол, www.egazar.gov.mn-сайт, газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хяналтын чиг үүрэг шилжиж ирсэн, салбарын хууль тогтоомжийн хүрээнд илэрч буй нийтлэг зөрчил, анхаарах асуудал, иргэн хуулийн этгээдийн эрх үүрэг, газрын зөрчил, маргаан, түүнээс урьдчилан сэргийлэх талаар тус тус мэдээлэл өгч, салбарын үйл ажиллагааг олон нийтэд таниулах сурталчлах ажлыг зохион байгуулж, иргэдийн сонирхсон асуултад хариулт өгч, зөвлөгөө өгч ажилласан болно.<br>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн Ерөнхий газраас нийслэлийн хэмжээнд 23 удаагийн сургалт, аймгуудын хэмжээнд 91 нийт улсын хэмжээнд 114 удаагийн сургалт зохион байгуулан 2389 мэргэжилтэн албан хаагч, 14924 иргэн, 763 хуулийн этгээдийг хамруулан зохион байгуулан ажилласан.<br>Хариуцлагатай газрын харилцаа аяны хүрээнд 18 зөвлөмж, 19 постер, 3 контент /ярилцлага/, 16 рээлийг байгууллагын фэйсбүүк хуудас болон пэйж хуудсанд байршуулж 163920 иргэний хандалт авсан байна. | | |

183

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4. Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах** | | | | | | | |
| 17. | **Арга хэмжээ 4.1** Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Төлөвлөгөөт бус шалгалт хийсэн объектын тоо | Нийт албан бичгийн хариутай 55, хариугүй, шийдвэрлэсэн 55 буюу 100%, хугацаа хоцорч шийдвэрлэсэн байхгүй, 20 өргөдөл, гомдол хүлээн авснаас шийдвэрлэсэн 20 буюу 100%. | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна<br>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийнэ. | Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 46 хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу холбогдох байгууллага, иргэн хуулийн этгээдэд зөвлөмж, чиглэл өгч, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан.<br>Тайлант хугацаанд улсын ахлах байцаагчийн баталсан 2 удирдамжаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж холбогдох байгууллага, иргэн хуулийн этгээдэд албан бичиг хүргүүлсэн байна. | 9-12 | |
| 18. | **Арга хэмжээ 4.2** Эрх бүхий байгууллага, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Төлөвлөгөөт бус шалгалт хийсэн объектын тоо | Нийт Барилга, хот байгуулалтын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарсан 2023 оны А/199, а/177 тушаалаар 1, Барилга, хот, байгуулалтын яамны Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 3 удирдамжаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, 2 удирдамжаар төлөвлөгөөт бус шалгалт<br>Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1267, А/1292 дугаар захирамжаар 1 төлөвлөгөөт бус | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна<br>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийнэ. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу улсын ахлах байцаагчийн баталсан 35-00-/02 дугаартай удирдамжаар нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн.<br>Нийслэлийн Засаг даргаас 2013-2023 онуудад газар эзэмшил, ашиглалттай холбоотой нийт 1992 захирамж гаргасан ба нийт 21523 иргэн, хуулийн этгээдийн (нэгж талбарын) эрх олгох, баталгаажуулах, газар эзэмших, ашиглах, эрх шилжүүлэх, талбайн хэмжээ болон байршил өөрчлөх, эрх цуцлах, хугацаа сунгах, газар ашиглалтын зориулалт өөрчлөх зэрэг асуудлыг шийдвэрлэсэн байна.<br>Хяналт шалгалтаар төрийн болон орон нутгийн өмчит сургууль, их сургууль, цэцэрлэг, эмнэлгийн газар олголтын байдлыг түүвэрчилсэн байдлаар хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. | 1-9 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хяналт шалгалтыг тус тус хийсэн. | | Сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэгийн газар эзэмшлийн талаарталбайн хэмжээ өөрчлөгдсөн 5 нэгж талбар, нягталж шалгах шаардлагатай 4 нэгж талбар байна. Ерөнхий боловсролын сургуулиас талбай хэмжээ өөрчлөгдсөн 14, их сургууль 4 нэгж талбар байна, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагаас 9 газрын талбай өөрчлөгдсөн байна. | | |
| 19. | **Арга хэмжээ 4.3** Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тоо | 4 хуулийн этгээд, 6 иргэний 10 хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 23.000.0 мянган төгрөгийн шийтгэл оногдуулан, барагдуулж зөрчлийн үр дагаврыг арилгах эрх бүхий албан тушаалтны даалгавар 10 хүргүүлсэн хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж зөрчлийг арилгуулсан. | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээг авсан байна. | Нийт 2 иргэний хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж хялбаршуулсан журмаар 2 иргэнд 1,000,000 төгрөгийн торгууль ногдуулснаас 1,000,000 төгрөгийг барагдуулж, зөрчлийн үр дагаврыг арилгах эрх бүхий албан тушаалтны даалгавар хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж зөрчлийг арилгуулсан. | 11-12 | |
| | | | **Зорилт 5. Хурал, зөвлөгөөн зохион байгуулах** | | | | |
| 20. | **Арга хэмжээ 5.1** Хариуцлагатай газрын харилцаа аян зохион байгуулах | Төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан арга хэмжээний тоо | - | Төлөвлөгөөний дагуу зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулна. | 1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсад газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тохиолдуулан хэрэгжүүлэх бүтээлч ажлын төлөвлөгөөний дагуу "Хариуцлагатай газрын харилцаа" аяныг 2024 оны 4 дүгээр сарын 01- | 4-6 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ний өдрөөс эхлэн 05 дугаар сарын 30-ны хооронд зохион байгуулахаар Газрын даргын А/88 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, Нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албанд 2024 оны 1/690, аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 1/691 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>2.Сонгинохайрхан, Багахангай дүүргийн иргэдэд салбарын хууль,Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль тогтоомжийг сурталчлах сургалт зохион байгуулсан.<br>4. Зөрчлийн тухай хуулийн Геодези, зураг зүйн тухай хууль зөрчих, Геодези, зураг зүйн тухай хуулийн талаар 3 постер бэлтгэж иргэд, олон Ерөнхий газрын пэйж хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд түгээсэн.<br>5. аяны хүрээнд Барилгын талбайд гүйцэтгэх, геодезийн ажлын бүрдэл, нарийвчилсан шаардлага хангаж буй эсэх, барилгын талбайд геодезийн үндэслэлийн цэг байгуулах, угсралтын түвшинд тэг тэнхлэг, өндөр дамжуулах үзүүлэх сургалтыг Барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагын инженер, техникийн ажилтнууд, Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх мэргэжлийн байгууллагууд болон Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Хөдөө Аж, Ахуйн Их Сургуулийн Геодезийн инженер мэргэжлээр суралцаж буй оюутнуудад 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Монголын геодези, фотограмметр, зураг зүйн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбоо, "Баясах сурвэй" ХХК-ийн Зөвлөх инженер, "Этүгэн инженеринг" ХХК-ийн мэргэшсэн инженерүүдтэй хамтран зохион байгуулсан. | | |
| **Зорилт 6. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | | | | | | | |
| 21. | **Арга хэмжээ 6.1**<br>Аймгуудын газрын харилцаа, хот байгуулалтын газрын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалтын тоо | Улсын байцаагчдыг чадавхжуулах танхимын сургалт 1, цахим сургалт 3 удаа зохион байгуулсан,. | Сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулсан байна. | Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газар, геодези, зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагчдад Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Газрын тухай хууль, Геодези зураг зүйн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын хүрээнд улсын (ахлах) байцаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, шинэ мэдлэг чадвар бий болгох замаар мэргэшсэн, хариуцлагатай, ур чадвар бүхий хамт олныг төлөвшүүлэн бүрдүүлэх, чадавхжуулах, мэргэшүүлэхэд сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 24, 25-ны зохион байгуулсан. | 1-4 | |
| 22. | **Арга хэмжээ 6.2**<br>Нийслэл, дүүргүүдийн газар зохион байгуулагч, бүртгэлийн мэргэжилтнүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулах | Батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалтын тоо | - | Сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулсан байна. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2024 оны 03 дугаар 19-ний өдрийн А/86 дугаар тушаалаар сургалт, хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг батлуулсан. Энэхүү ажлын хүрээнд нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, анхаарах асуудлын талаар зохион байгуулах сургалтын хөтөлбөрийг Газрын даргаар батлуулан 2024 оны 05 дугаар сарын 27, 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулан 63 мэргэжилтэн нарыг | 1-6 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамруулан сургалтыг зохион байгууллаа. | | |
| **Зорилт 7. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 23. | **Арга хэмжээ 7.1**<br>Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | Үүрэг даалгаврын тоо | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, шуурхайн биелэлтийг 8 удаа гаргаж тайлагнасан. | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | 1. Газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Газар, геодези, зураг зүйн салбарын 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 371 обьектын жагсаалтыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн хурлын шийдвэр гаргуулсан. Газрын даргын 2024 А/53 дугаарт тушаалаар баталсан.<br>2. Газрын даргын шуурхайгаас өгөгдсөн үүргийн дагуу аяны явцын мэдээг бэлтгэн удирдлагын зөвлөлд хүргүүлсэн. | 1-12 | |
| 24. | **Арга хэмжээ 7.2**<br>Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Тушаалд заасан хугацаа | Нийт 3 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлсэн. | Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны А/01 тушаалаар аймаг, нийслэлийн Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг хүлээн авч, нэгтгэх, нэгдсэн тайлан гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шалгалт, авсан арга хэмжээний тайланг улсын хэмжээнд нэгтгэж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 08 дугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн. | 1-9 | |
| 25. | **Арга хэмжээ 7.3**<br>Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | - | Жил бүр хийгддэг. | Жилийн эцсийн байдлаар нийт 41 албан бичиг ирсэнээс хариутай албан бичиг 26, хариугүй албан бичиг 15, шийдвэрлэсэн 40, хяналтад 1 албан | 9-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичиг байгаа бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хоног 8.4 байна. Нийт 5 өргөдөл гомдол ирсэн бөгөөд хариугүй 1, хариутай 4 өргөдөл гомдол байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8.8 хоног байна. | | |
| 26. | **Арга хэмжээ 7.4**<br>Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивд баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивд хүлээлгэн өгөх | Архивд хүлээлгэн өгсөн баримтын тоо | Хяналт шалгалтын баримт бичгийг хадгаламжийн нэгж үүсгэн 5 боть архивлан, 4 хуулийн этгээдийн хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, хавтаст хэргийг архивд хүлээлгэж өгсөн | Хяналт шалгалтын танилцуулгыг нэгтгэн архивд хүлээлгэн өг | 2023 онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын материалыг 4 боть архивын нэгж болгон холбогдох газарт хүргүүлсэн.<br>Мөн 2 иргэний хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, хавтаст хэргийг хадгаламжийн нэгж болгон архивласан. | 9-12 | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Төрийн албанд томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдах; | Хамрагдсан сургалтын тоо | - | 1 | Удирдлагын академаас зохион байгуулсан Төрийн албанд томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн. | 1-12 | |
| 2. | **Арга хэмжээ 2**<br>Зохион байгуулж буй сургалт, семинарт хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлэх | Хамрагдсан сургалтын тоо | - | 4 | Албан тушаалын онцлогоос хамаарсан дараах сургалт, семинарт хамрагдсан. Үүнд:<br>-2024 оны 02 дугаар 29-ний өдөр зохион байгуулагдсан “Ажил амьдралын тэнцвэр” сургалт;<br>-2024 оны 03 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд Удирдлагын академаас зохион байгуулсан "Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх аргачлал” сургалт;<br>- 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Архивын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан "Албан хэрэг хөтлөлт"-ийн аргазүйн сургалт;<br>-2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан “Байгууллагадаа хувь нэмэр оруулах нь” сэдэвт лекц; | 1-12 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | **Арга хэмжээ 2**<br>Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн сургалтад хамрагдах | Хамрагдсан сургалтын тоо | - | - | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хариуцсан албан хаагчаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авч бие даан суралцаж, ажлын хэрэгцээнд өдөр тутамдаа ашиглаж байна. | 9-12 | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ГАЗАР, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ ........................ (Э.ЮМЖИРМАА) 2024.12.04